

АШУУИС

2021.03.22 / №256

Online magazine **МЭДЭЭ**

АГУУЛГА

2 Нүүрт
АШУУИС-ИЙН БИО-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН 2-Р ЗЭРГИЙН "ЭМНЭЛЗҮЙН МОЛЕКУЛ ОНОШИЛГООНЫ ТӨВ"-ТЭЙ БОЛЛОО

3 Нүүрт
"ХҮНИЙ ИХ ЭМЧ" БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ / ASIIN / МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛЭЭР ДАВТАН ОРУУЛАХААР БОЛЛОО

4 Нүүрт
АШУУИС-ИЙН УДИРДЛАГУУД ЭРДМИЙН СУРГУУЛЬ ДЭЭР АЖИЛЛААА

5 Нүүрт
EBSCO ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САНГ ӨРГӨНӨӨР АШИГЛАНА УУ

6 Нүүрт
"SCIENCE" ЦАХИМ СУРГАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ АШУУИС-ИЙН БАГШ НАР УРИГДАН ОРОЛЦЛОО

7 Нүүрт
ДОТООД СУРГАЛТ

8 Нүүрт
СУВИЛАХУЙН ХӨГЖИЛ-21 БҮСИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛОО


"ХҮНИЙ ИХ ЭМЧ" БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ /ASIIN/ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛЭЭР ДАВТАН ОРУУЛАХААР БОЛЛОО



3 Нүүрт

Монгол улсад хүний их эмч бэлтгэх сургалтын тогтолцоог шинэчлэх, боловсронгуй болгох ажил шинжлэх ухааны үндэстэй тогтмол хийгдэж байгаа ба Анагаах ухааны сургуулийн "Хүний их эмч" бэлтгэх сургалтын хөтөлбөрийг олон улсын ASIIN магадлан итгэмжлэлээр

EBSCO ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САНГ ӨРГӨНӨӨР АШИГЛАНА УУ



5 Нүүрт

COVID-19 цар тахлын хөл хорионы нөхцөл байдлын үед EBSCO цахим мэдээллийн сангаас багш, оюутан, судлаач нарын цахим сургалт, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх үүднээс анагаах ухааны салбарын 4000 орчим цахим номын багцыг 3 сарын хугацаанд үнэ төлбөргүй

"ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ХҮМҮҮСИЙН ДЭЭД БОЛОВСРОЛЫН ХҮРТЭЭМЖ" СЭДЭВТ ОЛОН УЛСЫН VI ОНЛАЙН БАГА ХУРАЛ БОЛЛОО



13 Нүүрт

Евро-Азийн орнуудын шинжлэх ухаан, сурган хүмүүжүүлэх нийгэмлэгийг нэгтгэн Өвөр Байгалийн их сургуулиас уламжлал болгон зохион байгуулдаг олон улсын онлайн VI бага хурал 2021 оны 2-р сарын 25 нд зохион байгуулагдав.

АШУҮИС-ИЙН БИО-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН 2-Р ЗЭРГИЙН **"ЭМНЭЛЗҮЙН МОЛЕКУЛ ОНОШИЛГООНЫ ТӨВ"** – ТЭЙ БОЛЛОО

АШУҮИС-ийн удирдлагууд шинээр байгуулагдаж байгаа 260м² талбай бүхий **БИО-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН 2-Р ЗЭРГИЙН "ЭМНЭЛЗҮЙН МОЛЕКУЛ ОНОШИЛГООНЫ ТӨВ"**-ийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд лабораторийн засварын ажлын гүйцэтгэл, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, тохиргоо үйлчилгээ, урвалж оношлуур болон лабораторид ажиллах багийн хүний нөөцийн бэлэн байдалтай танилцаж тус лабораторийн үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэж ажиллалаа.



"ХҮНИЙ ИХ ЭМЧ" БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ /ASIIN/ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛЭЭР ДАВТАН ОРУУЛАХААР БОЛЛОО



Монгол улсад хүний их эмч бэлтгэх сургалтын тогтолцоог шинэчлэх, боловсронгуй болгох ажил шинжлэх ухааны үндэстэй тогтмол хийгдэж байгаа ба Анагаах ухааны сургуулийн **"Хүний их эмч"** бэлтгэх сургалтын хөтөлбөрийг олон улсын ASIIN магадлан итгэмжлэлээр Монгол улсад анх удаа 2016 оны 5 жилийн хугацаатай магадлуулсан билээ.


Цаашид сургалтын хөтөлбөрийг олон улсын стандарт, чанарт ойртуулж, үндэсний онцлогийг тусган улам боловсронгуй болгохоор ажиллаж байна. Үүний хүрээнд олон улсын магадлан итгэмжлэлийг давтан хийлгэхээр бэлтгэл ажлууд явагдаж, 2022 онд хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээ хийлгэхээр ажиллаж байна.

АШУҮИС-ИЙН УДИРДЛАГУУД ЭРДМИЙН СУРГУУЛЬ ДЭЭР АЖИЛЛАЛАА

Төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газар, Эрдмийн сургууль дээр АШУҮИС-ийн удирдлагууд ажиллан бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг сайжруулах, төгсөлтийн сургалтын чанарыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх хугацаатай үүрэг өглөө.

ВАКЦИНЖУУЛАЛТ ХИЙГДЭЖ БАЙНА


АШУҮИС-ийн Төв эмнэлэг нь Барс-2 худалдаа, худалдаа үйлчилгээний төвийн 295 түрээслэгч нарт Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг Астра зенека вакциныг хийж эхэллээ.



EBSCO ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САНГ ӨРГӨНӨӨР АШИГЛАНА УУ

COVID-19 цар тахлын хөл хорионы нөхцөл байдлын үед **EBSCO** цахим мэдээллийн сангаас багш, оюутан, судлаач нарын цахим сургалт, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх үүднээс анагаах ухааны салбарын **4000** орчим цахим номын багцыг 3 сарын хугацаанд үнэ төлбөргүй ашиглах боломжийг нээж байна.

Эдгээр цахим ном нь 2021 оны 6-р сарын 30-ны өдрийг хүртэл та бүхэнд нээлттэй байх болно.



The screenshot displays the EBSCOhost website interface. At the top, there is a navigation bar with links for "New Search", "Dictionary", "eBooks", "Sign In", "Folder", "Preferences", "Languages", "Help", and "Exit". The EBSCOhost logo is prominently displayed in the center. Below the logo, there is a search bar with the placeholder text "Enter any words to find books, journals" and a "Search" button. To the right of the search bar, there is a link for "Accessibility Information and Tips" and the text "MONGOLIAN NATIONAL UNIVERSITY OF MEDICAL SCIENCES(MNUMS)".

Below the search bar, there is a section titled "eBook Collection" with a "Browse By Category" sidebar on the left. The sidebar lists various categories such as "Biographies & Memoirs", "Body, Mind & Spirit", "Business & Economics", "Computer Science", "Cooking", "Education", and "Engineering &". The main content area features a "Highlights" section with a "View All" link. Below this, there is a carousel of book covers, including titles like "Surgical Management of Maxillofacial Fractures", "Handbook of Surgical Procedures", "Pediatric Environmental Health", "Red Book: Pediatric Infectious Diseases", "Case-Based Discussions in Medicine", "The Care Process: Assessment and Planning", "Dermatoscopy and Skin Cancer", "Paediatrics: A Clinical Handbook", and "A Closer Look at Fibroblasts".


"SCIENCE" ЦАХИМ СУРГАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ АШУУИС-ИЙН БАГШ НАР УРИГДАН ОРОЛЦЛОО

БШУЯ-ны дэргэдэх Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институтийн Дээд боловсролын хөгжлийн албанаас их, дээд сургуулийн багш нарын дунд зохион байгуулагддаг

"SCIENCE" цахим хэлэлцүүлэг 2021 оны 2-р сарын 19-ны өдөр "Их, дээд сургуулийн багшид ментор ба ментийгийн ойлголтыг бий болгох нь" сэдвийн хүрээнд амжилттай зохион байгуулагдлаа.

Тус цахим сургалт-хэлэлцүүлэгт "Дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд АШУУИС-дээр хэрэгжсэн "Суралцахуйн увдис "төслийн үр дүнгийн талаар БАС-ийн Харилцааны ур чадварын тэнхмийн эрхлэгч, доктор, профессор С.Наранчимэг, "Ментийгээс ментор болох нь" сэдэвт илтгэлийг Сувилахуйн сургуулийн ахлах багш, доктор, дэд профессор Д.Солонго танилцуулж, хэлэлцүүлэгт оролцогсдын асуултад хариулахаас гадна туршлагаа хуваалцсан сонирхолтой хэлэлцүүлэг боллоо.

Тус хэлэлцүүлэгт улсын ба хувийн их, дээд сургуулийн 800 орчим багш оролцсон бөгөөд "Google meet" программ ашиглахаас гадна "Их дээд сургуулийн профессор багш нар" фэйсбүүк групп хаягаар олон нийтэд шууд дамжууллаа.



**БАС-ийн Харилцааны ур
чадварын тэнхим**



● ДОТООД СУРГАЛТ

“XXI зууны хөгжлийн чиг хандлага, хувь хүний хөгжлийн манлайлал” сэдэвт модуль сургалтад (нийт 12 цаг) ЗХНА-ны 23 ажилтан, ажилчид хамрагдан сертификатаа гардан авлаа. Сургалтыг Боловсролын удирдлагын доктор, МУ-ын үндэсний хэмжээний манлайлалын мастер сургагч багш Г.Бямбажав удирдан зохион байгууллаа.




СУВИЛАХУЙН ХӨГЖИЛ-21 БҮСИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛОО

Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдэд зориулан АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны сургууль, аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран жил бүр зохион байгуулдаг бүсийн эрдэм шинжилгээний хурал 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр цахим хэлбэрээр амжилттай болж өндөрлөлөө. Тус хуралд Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Орхон, Дорнод, Дархан-Уул аймгийн сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн эхний шатанд ирүүлсэн 26 илтгэлээс шалгарсан 12 илтгэлийг хэлэлцүүлж, тэргүүн байранд Дархан-Уул аймгийн НЭ-ийн Сүрьеэгийн тасгийн сувилагч Б.Хонгорзул¹, Д.Нармандах¹, Л.Ууганбаяр¹, Д.Оюунцэцэг² нарын “Сүрьеэтэй эмчлүүлэгчдийн хоногийн хоолны хэрэглээ, шим тэжээлийг үнэлэх нь”, дэд байранд мөн аймгийн НЭ-ийн Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасгийн сувилагч Д.Наранцэцэг¹, Б.Ягаанцэцэг¹, Ч.Пүрэвжаргал¹, Д.Оюунцэцэг² нарын “Өвдөлт намдаах тарилга хийж буй хэрэгсэл, түүний үр дүнг харьцуулан судлах нь”, гутгаар байранд хагалгааны нэгдсэн тасгийн сувилагч Ц.Сарангэрэл¹, П.Нямаа¹, Ч.Пүрэвсүрэн¹, Л.Отгонтөгс² нарын “Коронавирусийн халдварын /COVID-19/ үеийн сувилагч, эмнэлгийн



тусгай мэргэжилтний сэтгэлзүйн бэлэн байдлыг судлах нь”, тусгай байранд Архангай аймгийн нэгдсэн эмнэлгийн Мэс заслын тасгийн сувилагч Г.Уранчимэг1, М.Мөнхчимэг1, М.Ариунжаргал1, Л. Нямдалай1 нарын “Хэвтэн эмчлүүлэгчдийн асаргаа сувилгаанд хийсэн судалгаа”, Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлгийн Мэс засал, гэмтлийн тасгийн сувилагч Н.Төгсжаргал, Г.Оюунжаргал нарын “Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс засал, гэмтлийн тасгийн ээлжийн сувилагчийн ажлын ачааллыг судлах нь”, Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлгийн Сэргээн засах эмчилгээний

тасгийн сувилагч Ш.Чанцалням1, Д.Энхжаргал1, С.Энхжаргал1, Я.Билэгмаа2 нарын “Нэгдсэн эмнэлгийн зарим эмч, ажиллагсдын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин, дасгал хөдөлгөөн хийдэг байдлыг судалсан нь” сэдэвт илтгэлүүд тус тус шалгарлаа. Эрдэм шинжилгээний хурлын шүүгчээр Дархан-Уул аймгийн НЭ-ийн ерөнхий эмч Б.Мөнхбат, АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны сургуулийн ЭШМТ-ийн албаны дарга, эм зүйн ухааны доктор О.Отгонтоогоо, НЭ-ийн Сувилахуйн албаны арга зүйч Р.Оюунтуяа нар ажиллаа.



АШУУИС-ИЙН ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ САЛБАР АНАГААХ УХААНЫ СУРГУУЛЬ ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ISO 9001:2015 ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ДАВТАН БАТАЛГААЖУУЛАЛТАНД АМЖИЛТТАЙ ХАМРАГДЛАА

АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль нь ОЛОН УЛСЫН СТАНДАРТАД НИЙЦСЭН ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛДЭГ НЭЭЛТТЭЙ СУРГУУЛЬ БОЛОХ эрхэм зорилгынхоо хүрээнд 2017 оноос чанарын менежментийн тогтолцооны олон улсын ISO 9001:2015 стандартыг сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр байгууллагын ажлын уялдаа холбоо сайжирч, бүтээмж, цаг ашиглалт нэмэгдэхийн зэрэгцээгээр багш, оюутан, төгсөгчдийн сэтгэл ханамжийг тасралтгүй нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлдэг давуу талтай. Тус сургуульд хэрэгжиж буй чанарын менежментийн тогтолцооны олон улсын ISO 9001:2015 стандартын давтан аудит 2021 оны 02 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд стандарт хэмжилзүйн газрын даргын тушаалын дагуу СХЗГ-ын ахлах аудитор Л.Золзаяа, Дархан-Уул аймгийн СХЗХ-ын аудитор Б.Баярбаатар нар цахим, танхим хосолсон хэлбэрээр аудитыг явуулж гэрчилгээг амжилттай үргэлжлүүлэн эзэмших аудитын багийн дүгнэлт гаргасан байна.





Нэвтрүүлэх туршилт хийгдэж байна

АШУҮИС-ИЙН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН СУУРЬ **UNIVERSEMED V1.0** СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ИННОВАЦИЙН ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ, ХЭРЭГЛЭЭНД НЭВТРҮҮЛЭХ ТУРШИЛТ ХИЙГДЭЖ БАЙНА.

АШУҮИС-ийн Шинжлэх ухаан, технологийг дэмжих сангийн санхүүжилттэй АШУҮИС-ийн Цахим засаглалын суурь UniverseMed v1.0 системийг хөгжүүлэх инновацийн төслийг ШУТГ-ын Инноваци технологи дамжуулах төв болон Вүүвүү технологи ХХК, АШУҮИС-ийн Захиргаа, Хүний Нөөцийн Газар, Мэдээлэл Технологийн Алба хамтран Эрдэм шинжилгээ, гадаад харилцаа хариуцсан дэд захирлын удирдлагаар нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэн, хэрэглээнд нэвтрүүлэх туршилт хийгдэж байна.


Төслийн хүрээнд “Хүний нөөцийн удирдлагын систем, Тушаал-Албан хэрэг хөтлөлтийн систем, Төслийн удирдлагын систем” гэсэн цахим засаглалын суурь 4 модулийг эхний ээлжид нэвтрүүлэх юм. Мөн энэ төсөлтэй уялдан “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн цахим системд нэвтрүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна.

Хянасан: Б.Дамдиндорж (ЭШГХ Дэд Захирал)
Н.Орхон (ЗХНГ-ын дарга)
Д.Отгонбаяр (ШУТГ-ын дарга)

Боловсруулсан: Ц.Хонгорзул (ЗХНГ-ын мэргэжилтэн)
З.Отгон (Төслийн удирдагч)

МОНГОЛД СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУВИЛАГЧ БЭЛТГЭХ ТӨГСӨЛТИЙН ДАРААХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ТУРШИЛТ СУРГАЛТЫН МОДУЛЬ-2 АМЖИЛТТАЙ ЯВАГДАЖ ДУУСЛАА


MoMeNT төслийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн мэргэшүүлэх сургалтын Модуль 2 болох “Эмнэл зүйн харилцааны сувилахуйн менежмент” сургалт 2021.02.03 наас 2021.03.03 амжилттай явагдаж дууслаа. Модулийг СС-ийн багш Ж.Мөнхханд, СЭМҮТ-ийн сувилагч багш Д.Мөнгөнцэцэг нар удирдан явууллаа. Сургалтын явцад суралцагчдын идэвх сайн олон шинэ мэдээллийг хүлээн авч семинарын хичээлээр мэдлэгээ бататгаж амжилттай зохион байгуулагдлаа. Суралцагч болон багш нарын хамтарсан хэлэлцүүлгийг хийж сургалтын явцад олж авсан ололт, цаашид агуулга, арга зүйн талаас анхаарах зүйл дээр хамтран ярилцаж хэлэлцүүлээ. “Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээ” сэдвийн хүрээнд Модул 3 сургалт амжилттай эхлэн явагдаж байна.



"ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ХҮМҮҮСИЙН ДЭЭД БОЛОВСРОЛЫН ХҮРТЭЭМЖ" СЭДЭВТ ОЛОН УЛСЫН VI ОНЛАЙН БАГА ХУРАЛ БОЛЛОО

Евро-Азийн орнуудын шинжлэх ухаан, сурган хүмүүжүүлэх нийгэмлэгийг нэгтгэн Өвөр Байгалийн их сургуулиас уламжлал болгон зохион байгуулдаг олон улсын онлайн VI бага хурал 2021 оны 2-р сарын 25 нд зохион байгуулагдав. Олон улсын онлайн бага хурлыг Оросын Холбооны Улсын Өвөрбайгалийн их сургуулийн доктор, профессор, "Экологи ба хүний эрүүл мэнд" шинжлэх ухаан боловсролын төвийн дарга, ОХУ-ын гавъяат эмч Кохан Сергей Тихонович удирдан явуулав.

"Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дээд боловсролын хүртээмж" сэдэвт VI олон улсын онлайн хуралд Оросын Холбооны Улсын Өвөр Байгалийн Их сургууль, Бүс нутгийн инклюзив боловсролын төв, Новосибирскийн их сургууль, Донецкийн Анагаах ухааны их сургууль, АШУҮИС, ОХУ-ын Чита, Череповец хотын эрдэмтэн багш, судлаач нар оролцож, тусгай хэрэгцээт хүмүүсийн боловсрол, дээд боловсролын хүртээмж, боловсролын түвшинг дээшлүүлэх, тодорхойлох энэ талаархи мэдээлэл цуглуулах, зайн сургалтын талаархи олон илтгэл тавьж хэлэлцүүлэв. Хуралд Оросын Холбооны Улсын Өвөрбайгалийн их сургуулийн доктор, профессор, "Экологи ба хүний эрүүл мэнд" шинжлэх ухаан боловсролын



төвийн дарга, ОХУ-ын гавъяат эмч Кохан Сергей Тихонович боловсролын систем дэх зайн сургалтанд суралцагчдын сэтгэл ханамжийн байдал, доктор профессор Варина Ольга Александровна тусгай хэрэгцээт хүмүүсийн харилцаа хандлага, Можайкина Людмила Борисовна онлайн сургалтын талаар, Михайловна Александра Владиславовна тусгай хэрэгцээт хүмүүсийг мэдээлэлээр хангах талаархи нийт 13 илтгэл тавигдлаа.

АШУҮИС-ийн Биологаахын сургуулийн багш, АУ-ны доктор, профессор Б.Ариунсанаа, Эм зүйн сургуулийн багш, Эм зүйн ухааны доктор, дэд профессор Б.Баясгалан нар "Монгол орон дахь тусгай хэрэгцээт боловсролын асуудалд" сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэв.


Тусгай хэрэгцээт боловсролын хүртээмжтэй байх асуудал нь оюутны хувь хүний болон мэргэжлийн хөгжлийн үйл явцыг дэмжих, практик үйл ажиллагааны хамтын оролцоог идэвхжүүлэх, боловсролын байгууллага, багш, судлаач, мэргэжилтнүүд, гэр бүлийн хамтын оролцоог сайжруулах зэрэг олон асуудалтай холбоотой болохыг тэмдэглэв.

"ONE HEALTH AND COVID-19" СЭДЭВТ ОЛОН УЛСЫН СЕМИНАР ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

НЭМС-ийн Эрүүл мэндийн бодлогын тэнхим Knowledge Sharing & Growing Forum, Идэр Их Сургуулийн Korean School of Business болон Michigan State University дахь Institute for Global Health байгууллагуудтай хамтран "One health and Covid -19" сэдэвт олон улсын семинарыг 2021 оны 2-р сарын 16-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Тус семинарт Institute for Global Health-ын дэд захирал доктор, професор Sungsoo Chung, Korean School of Business-ийн захирал доктор, професор Young-Rae Kim, Идэр Их Сургуулийн захирал доктор, профессор Д.Зоригт, Рафаэл Интернэйшнл ТББ-ын менежер Д.Энхзаяа, НЭМС-ийн Эрүүл мэндийн бодлогын тэнхимийн багш нар, магистрантууд, болон эрүүл мэндийн мэргэжилтнүүд оролцлоо.

Семинарын үеэр Коронавируст цар тахлын үед АНУ болон Монгол оронд авч хэрэгжүүлж буй арга туршлагыг харилцан танилцуулж, цаашдын хамтын ажиллагааны чиглэл, боломжуудын талаар санал солилцлоо.

НЭМС нь 2011 оноос хойш Michigan State University дахь Institute for Global Health байгууллагатай хамтран сургалт, судалгааны төсөлт ажлыг амжилттай хэрэгжүүлсэн туршлагатай бөгөөд энэхүү семинар нь хоёр сургуулийн хоорондын хамтын ажиллагааг үргэлжлүүлэх ажлын эхлэл болсноороо чухал ач холбогдолтой уулзалт боллоо.





“ӨРХ, СУМЫН ТҮВШИНД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН НЭН ШААРДЛАГАТАЙ АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ” НОМЫГ АШУУИС-Н НОМЫН САНД БЭЛЭГЛЭЛЭЭ

“Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт” (БНЭМХ)—ыг бүх хүн чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг төлбөр төлөхтэй холбоотойгоор санхүүгийн хүндрэлд оролгүйгээр авах гэж тодорхойлсон ба энэ нь эрүүл мэндийн салбарын хөгжлийн алсын хараа юм (ДЭМБ 2019).

Бүх нийтийн хамралтад хүрэхэд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхийг бэхжүүлэх үндсэн зорилт юм. Монгол улсын 500 гаруй сум, өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж буй эмч, мэргэжилтнүүдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэгсдийн чадавхийг сайжруулах төгсөлтийн дараах урт ба богино хугацааны сургалтыг АШУУИС-н Өрхийн анагаах ухааны тэнхим ЭМЯ болон ДЭМБ-тай хамтран зохион байгуулсаар ирсэн билээ.


“Өрх, сумын түвшинд үзүүлэх нэн шаардлагатай эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ” сургалтыг хамтран зохион байгуулж байгаа бөгөөд сургалтын багц номыг өнөөг хүртэл эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний орчин үеийн нотолгоо, баримт, сэдвүүдээр баяжуулан, шинэчилсээр байна.

2018 онд Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх төслийн хүрээнд Эрүүл Мэндийн Сайдын А/374 тоот тушаалаар баталсан Техникийн зөвлөлийн бүрэлдэхүүнд АШУУИС-ийн төлөөлөл багтсан бөгөөд техникийн зөвлөлийн хурлаар АШУУИС нь “Өрх, сумын түвшинд үзүүлэх нэн шаардлагатай эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ” сургалтын багц номыг дахин хянан засварлаж бүтээх үүрэг хүлээсэн юм. Тус номыг шинэчлэн, хянан засварлаж бүтээх төслийн хүрээнд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай байгаа эх, хүүхэд, халдварт ба халдварт бус өвчин, яаралтай тусламж, ахмад настан, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ, лаборатори, оношилгооны тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, амны хөндийн эрүүл мэнд зэрэг модулиудыг багтаасан нийт 70 хэвлэлийн хуудас бүхий 90 ширхэг номыг төгсөлтийн өмнөх болон дараах сургалтанд ашиглах зорилгоор АШУУИС-ийн төв номын санд бэлэглэлээ.

"СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ"

ЦАХИМ СУРГАЛТЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА




2021 оны 02 сарын 24-нд АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь АУС-ийн Мэргэжлийн суурь эрдмийн тэнхим, Нэгдсэн эмнэлгийн сувилахуйн алба, Эрүүл мэндийн газартай хамтарч "Судалгааны арга зүй" цахим сургалтыг Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн сувилагч тусгай мэргэжилтнүүд, УАУТөв, сум, өрх, хувийн хэвшлийн сувилагч тусгай мэргэжилтнүүд дунд амжилттай зохион байгууллаа. Сургалтыг нээж Нэгдсэн эмнэлгийн дарга АУ-ны магистр Ш.Мэндсайхан үг хэлж, МСЭТ-ийн эрхлэгч АУ-ны доктор Д.Оюунцэцэг, БС-ын доктор Ч.Мандалсайхан, АУ-ны магистр Х.Зандармаа, Эм лабораторийн тэнхимийн ахлах багш БС-ын доктор Ж.Одонтуяа, Нэгдсэн эмнэлгийн сувилагч БС-ын магистр, Сувилахуй судлалын зөвлөх О.Гантуяа нар судалгааны ажлын бүтэц, судалгаа хийхэд анхаарах зүйлс, түүвэр цуглуулах, боловсруулалт хийх, асуумжийн хуудас боловсруулах, сувилахуйн судалгааны арга зүй сэдвүүдээр сургалт хийлээ. Энэхүү сургалт нь сувилагч тусгай мэргэжилтнүүдийг багаар хамтарч эрдэм шинжилгээ судалгааны ажлыг хийх, судалгааны арга зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, судалгааны ажлын цар хүрээг өргөжүүлэх зорилготой явагдлаа.



"БИД ХАМТДАА" ТӨГСӨГЧДИЙН ЭЭЛЖИТ ЦАХИМ УУЛЗАЛТ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

2021 оны 03 сарын 13-нд АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь АУС-ийн Мэргэжлийн суурь эрдмийн тэнхим, эмнэл зүйн I тэнхимтэй хамтран "БИД ХАМТДАА" төгсөгчдийн цахим уулзалтыг амжилттай зохион байгууллаа. Уулзалтыг нээж АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь АУС-ийн захирал, АУ-ны доктор, клиникийн профессор М.Банзаагаяа үг хэллээ. Уулзалтанд тус сургуулийн 2013 оны төгсөгч Ховд аймгийн БОЭТ-ийн гэмтлийн тасгийн гэмтэл согог заслын их эмч Н.Бэрхбол, 2012 оны төгсөгч Улсын 2-р төв эмнэлгийн нэгдсэн лабораторийн эмгэг судлаач их эмч Х.Жанибек, 2011 оны төгсөгч Говь-Алтай аймгийн "Эрүүл ирээдүй" мэс засал, гэмтлийн эмнэлгийн мэс заслын их эмч Ц.Даваадорж, 2012 оны төгсөгч Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн Эрчимт эмчилгээний тасгийн мэдээгүйжүүлэгч их эмч Т.Санчир-Од нар оролцож өөрсдийн ажлын туршлага болон суралцах арга барилаасаа багш, оюутан суралцагчид, төгсөгчидтэй хуваалцлаа. Оролцогч эмч нар маань баруун бүс нутагтаа хүн ардынхаа эрүүл энхийн манаанд хоёргүй сэтгэлээр амжилттай ажиллаж яваа манай сургуулийн шилдэг төгсөгчид юм. Тэд эмч хүн тасралтгүй сурч, хэлний мэдлэгээ оюутан байхаасаа төгс эзэмших, хандлагаа өөрчлөх гэсэн олон сайхан зүйлийг ярилцаж, сурч байгаа оюутнуудад сургамж, зөвлөгөө зөвлөмжийг өгсөн сайхан уулзалт боллоо. Цахим уулзалтанд багш нар, тус сургуулийн үе үеийн төгсөгчид, суралцаж буй оюутан залуус оролцлоо.

Цаашид энэхүү арга хэмжээг төгсөгчдийнхөө амжилт бүтээлийг тайлагнан сурталчилж, баруун бүс нутагт төдийгүй эх орондоо мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгчдийнхөө үйл ажиллагааг нэгтгэн, олон талт туршлага хуримтлуулсан залуучууд эвлэлдэн нэгдэж, чадварлаг эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэхэд гүүр болсноор сургууль болон төгсөгчдийн хамтын ажиллагааг өндөр түвшинд хүргэхээр зорин ажиллана.





Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
АШУУИС-ийн төв байр, 250 тоот



mnums.edu.mn



medee@mnums.edu.mn



11-329420